



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НАРТ

**ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
01 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8,  
Финанс төв  
Утас: 70118585, Факс: (976) 70119595  
Цахим шуудан: info@erdenestt.mn

2019. 06. 14 № 12/1511

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Тендерийн баримт бичигт  
өөрчлөлт орсон тухай**


"Тавантолгойн ордын Цанхийн хэсгийн ашиглалтын хайгуулын өрөмдлөгийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах" ЭТТ/201901108 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичгийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас хянаад 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн №1/1012 тоот "Тендерийн баримт бичгийг хянасан тухай" албан бичиг ирүүлснийг тус тендерийн үнэлгээний хороо 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдөр хэлэлцээд дараах шийдвэрийг гаргасан болно. Үүнд:

1. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТООЗ 5.3(в)-т "Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд: Гүйцэтгэгч компани нь өөрийн эзэмшлийн хүчин чадал сайтай дэвшилтэт технологийн өрөмдлөгийн 10-аас доошгүй машин (1000 метр хүртэл өрөмдөх, үүнээс 1-2 нь 1500 метр хүртэл өрөмдөх хүчин чадалтай) бусад шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй байх" гэсэн шаардлагыг

"Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд: Гүйцэтгэгч компани нь өөрийн эзэмшлийн хүчин чадал сайтай дэвшилтэт технологийн өрөмдлөгийн 7-оос доошгүй машин (1000 метр хүртэл өрөмдөх, үүнээс 1-2 нь 1500 метр хүртэл өрөмдөх хүчин чадалтай) бусад шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй байх. Нөөцөд өрөмдлөгийн 3-аас доошгүй машинтай байх (өөрийн эзэмшлийн байх шаардлагагүй)." гэж өөрчилсөн болно.

Мөн Тендерийг 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 10 цаг 00 минут-аас өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА

  
Ц.АНХБАЯР